



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 1 дүгээр  
сарын 7-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар  
хот

Гадаадаас 2015 онд авах ажиллах хүч,  
мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4, 7.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:


1. Монгол Улсад 2015 онд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажиллагчдын тоонд эзлэх гадаадын ажиллах хүч, мэргэжилтний хувийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын хавсралтад заагдаагүй салбарт гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар тогтоосугай.

3. Аж ахуйн нэгж, байгууллага нь 30-аас доош тооны гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн авах бол тухай бүр салбарын сайдын хүрээнд, 30-аас дээш бол Засгийн газарт асуудлыг тавьж шийдвэрлүүлж байхыг Хөдөлмөрийн сайд С.Чинзоригт үүрэг болгосугай.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулж байхыг Эрүүл мэнд, спортын сайд Г.Шийлэгдамбад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлан ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хөдөлмөрийн сайд

С.ЧИНЗОРИГ

2015 ОНД АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ  
ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ ХУВЬ

Салбар	Дэд салбар	Бүлэг	Анги	Тодорхойлолт	Нийт ажиллагчдын тоо					
					50 хүртэл	51-100	101-150	151-200	201-250	251-ээс дээш
<b>B</b>	<b>УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ</b>									
	06			Түүхий газрын тос, байгалийн хийн олборлолт	60	70	70	75	75	75
	09	099	0990	Түүхий газрын тос, байгалийн хийн хайгуул	60	70	70	75	75	75
	09	099	0990	Уул уурхайн олборлолтын туслах бусад үйл ажиллагаа	20	25	25	25	25	25
<b>C</b>	<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР</b>									
	10			Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	8	9	9
	13			Нэхмэлийн үйлдвэрлэл	5	6	7	8	9	9
	20			Хими, химийн төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	8	9	10	11	12	12
	23			Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	5	9	10	12	13	15
	24			Металл үйлдвэрлэл	5	5	5	10	12	15
	32			Бусад боловсруулах үйлдвэрлэл	8	9	10	11	12	12
	33			Машин, тоног төхөөрөмжийг угсрах, суурилуулах, холбогдох засвар үйлчилгээ	20	20	25	25	25	25
<b>D</b>	<b>ЦАХИЛГААН, ХИЙ, УУР, АГААРЖУУЛАЛТ</b>									
<b>E</b>	<b>УС ХАНГАМЖ, БОХИР УС ЗАЙЛУУЛАХ СИСТЕМ, ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ БОЛОН ЦЭВЭРЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>									
					5	6	6	7	8	9
<b>F</b>	<b>БАРИЛГА</b>									
	41	410	4100	Барилга угсралт	15	15	15	20	22	25
				Уул уурхайн барилга угсралт	20	22	25	25	30	35
		421	4210	Төмөр зам болон авто замын байгууламж барих үйл ажиллагаа	20	25	30	35	40	45
<b>G</b>	<b>БӨӨНИЙ БОЛОН ЖИЖИГЛЭН ХУДАЛДАА, МАШИН, МОТОЦИКЛИЙН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ</b>									
		45		Моторт тээврийн хэрэгсэл, мотоциклийн бөөний болон жижиглэн худалдаа, засвар үйлчилгээ	20	20	20	20	20	20
<b>H</b>	<b>ТЭЭВЭР БА АГУУЛАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b>									
					25	25	25	25	25	25
<b>I</b>	<b>ЗОЧИД БУУДАЛ, БАЙР, СУУЦ БОЛОН НИЙТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭ</b>									
	55			Зочид буудал, байр сууцаар үйлчлэх үйл ажиллагаа	5	5	5	10	10	10

	56			Нийтийн хоолны үйлчилгээ	10	10	10	10	10	10
M	МЭРГЭЖЛИЙН, ШИНЖЛЭХ УХААН БОЛОН ТЕХНИКИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА									
	72			Шинжлэх ухааны эрдэм шинжилгээ, ололт, судалгааны үйл ажиллагаа	30	30	30	30	30	30
N	УДИРДЛАГЫН БОЛОН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА									
		791		Аялал, жуулчлалын агентлаг, аяллын операторын үйл ажиллагаа	10	15	20	20	25	25
P	85	БОЛОВСРОЛ								
		851, 852, 854		Бага болон бүрэн дунд, бусад боловсрол олгох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30
		853, 8522, 8530		Техник мэргэжлийн дунд боловсрол болон дээд боловсрол олгох үйл ажиллагаа	30	30	30	30	30	30
				Засгийн газар хоорондын гэрээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай, олон улсын хөтөлбөрөөр сургалт явуулдаг боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагаа	70	70	70	80	80	80
Q	ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНД БА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА									
		86		Хүний эрүүл мэндийн үйл ажиллагаа	5	6	6	7	8	9
		87		Оршин суугчдад үзүүлэх халамжийн үйл ажиллагаа	5	10	15	15	20	20
R	УРЛАГ, ҮЗВЭР, ТОГЛООМ НААДАМ									
	90	900	9000	Бүтээл туурвих, урлаг, үзвэр, үйлчилгээний үйл ажиллагаа	5	5	5	5	5	5
	93			Спорт, зугаа цэнгэл, чөлөөт цагийн үйл ажиллагаа	5	5	5	5	5	5
S	ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА									
	95			Хувийн болон өрхийн хэрэглээний зориулалттай бараа, компьютерийн засвар, үйлчилгээ	5	6	6	7	8	9
	96	960		Хувийн үйлчилгээний бусад үйл ажиллагаа	5	6	6	7	8	9
U	ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА, СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА									
	99	990	9900	Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	40	40	40	40	40	40
				Гадаадын аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөлөгчийн газар мөн хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын төрийн бус байгууллага	30	30	30	30	30	30

Жич: 20 хүртэлх монгол ажиллагчидтай аж ахуйн нэгж, байгууллага нь 1 гадаадын иргэн ажиллуулж болно.